

**Бидэнд хандаарай – бид танд мэргэжлийн,  
үнэ төлбөргүй зөвлөнө!**

# Чех улсад оршин суух зөвшөөрлийн мэдээлэл

## буюу

# Нийтлэг асуултнуудын хариу

**ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ+**

InBáze 2013



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY

Цагаач иргэдэд зөвлөгөө тусламж үзүүлэх ИнБазэ III төсөл нь гуравдагч орны иргэдэд дасан зохицох бололцоог бүрдүүлэх Европын Фондоос болон Чех улсын Дотоод хэргийн яамнаас санхүүжсэн болно.

Та Европийн холбооны гаднах улсын иргэн үү? Та Чех улсад оршин суумаар байна уу эсвэл энд амьдардаг уу? Тэгвэл энэхүү нийтлэл танд зориулсан. Бид танд оршин суух зөвшөөрөлтэй холбоотой нийтлэг асуултнуудад хариулт өгнө.

## ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

**ОРС** – Чех улсын ДХЯ – ны гадаад иргэдийн оршин суух асуудлыг хариуцсан хэлтэс

**Захиргааны шийдвэрлэлт** / Správní orgán / – Чех улсын ДХЯ – ны цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшуулах алба

**Цагдаа** / Policie / – Чех улсын гадаадын иргэдийг хариуцсан цагдаагийн хэлтэс

**Нутаг дэвсгэр** / Území / – Чех улсын нутаг дэвсгэр

### ТУС УЛСАД ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ ГАРГАХ БА ХАВСРАЛТУУД

Тус улсад удаан хугацааны оршин суух, түүний сунгалт эсвэл байнга оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргаж байвал ногоон маягт бөглөнө үү.


**Өргөдөл гаргахдаа юунд анхаарах вэ?**

## ӨРГӨДЛӨӨ ХУГАЦААНД НЬ ГАРГАХ ЁСТОЙ

- Хүсэлтийг одоо байгаа оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө 90 – 14 хоногт багтаан гаргана
- Удаан хугацааны оршин суух эрхийн дуусах хугацааны сүүлийн өдөр зорилго өөрчлөхийг зөвшөөрнө (жнь: суралцахаас бизнес эрхлэхрүү)
- Бүрдүүлэх шаардлагатай бүх материалыг иж бүрнээр нь хавсаргавал өргөдлийн шийдвэрлэх ажиллагааг түргэсгэнэ. Өргөдлийн материалд ямар нэгэн баримт дутсан ч маягтаа цаг хугацаанд нь өгөх шаардлагатай. Дутсан баримт бичгийг дараа нь нөхөн бүрдүүлж өгч болно. Хэрвээ бүрдүүлж өгөөгүй тохиолдолд захиргааны байгууллага өргөдлийн шийдвэрлэлтийг түр зогсоох ба дутуу бичиг баримтыг бүрдүүлж өгөхийг шаардана. Материалыг нөхөн бүрдүүлэх хугацаа заана.


## ӨРГӨДӨЛ ГАРГАХ ХУГАЦААНААС ХОЦОРСОН – Одоо яах вэ?

- Хугацаа хэтэрсэнийг зөвхөн **хүндэтгэх шалтгааны** улмаас харгалзаж уучилана (жнь: хүнд өвчин).
- Гарсан саатал арилмагц **3 хоногийн** дотор хүсэлтээ гаргах үүрэгтэй.
- Өргөдлөө өгөхдөө хугацаа хэтрүүлсэнд **уучлалт гуйсан өргөдөл** бичиж, өвчний акт зэрэг гарсан шалтгааныг нотолсон баримт бичгийн хамт бүрдүүлнэ (жнь: Хэрвээ та өвчтэй байсан бол эмчийн тодорхойлолт).

 Та хүндэтгэсэн шалтгаангүй хугацаандаа өргөдлөө гаргаагүй бол, таны өргөдлийг хүлээж авахгүй. Хэрвээ та мартсан бол шалтгаанд тооцохгүй.

## ӨРГӨДЛИЙН ХАВСРАЛТУУД

- Баримтууд нь **180 хоногоос хэтэрсэн** байж болохгүй (үүнд өөрчлөгддөггүй ба хэдэн жилийн дараа өөрчлөгддөг баримтууд хамаарахгүй. Жнь: гадаад паспорт, байрны түрээсийн гэрээ, Чех хэлний төвшингийн баримт, г. м).
- Бүх шаардлагатай баримтууд Чех **хэлрүү албан ёсоор орчуулагдсан** байх ёстой.
- Та баримтуудаа зөвхөн эх **хувиар, эсвэл баталгаажуулсан хуулбараар** өгөх ёстой. Та нотариат, хотын хэсгийн захиргаа буюу Чех поинттой шуудан дээр эх хувиа үзүүлэн хуулбараа баталгаажуулна.

 Хэрвээ та баримтуудаа өөрийн биеэр өгч байвал, өмнө нь жирийн хуулбарууд хийгээд, эх хувьтай нь цуг хүлээлгэн өгнө. Албан хаагч эх хувийг хуулбартай нь харьцуулж шалгах болно. Эх хувь нь танд буцаан олгогдоно

- Та баримтуудаа шуудангаар илгээж болно, тэгэхдээ баталгаажуулсан хуулбарууд байх ёстой. Баталгаат шуудангаар илгээгээрэй, баталгааны жижиг хуудсыг, явуулсан нотолгоо болгож хадгалаарай. Илгээсэн баримт дээрээ өөрийн **өргөдлийн дугаараа** бичнэ үү
- Таны өргөдөл хуулиар заасан шаардлагыг хангаж байгаа гэдгийг нотолсон баримт өгч болно. Энэ бол таны эрх, мөн

үүрэг. Захиргааны байгууллага эсвэл хуулиар шаардсан баримтууд хамгийн чухал. Захиргааны байгууллага мөн алба хаагч таны өргөдөлд хамаарсан баримтуудыг хүлээн авахыг татгалзах эрхгүй. Таны өргөдлийг шийдхэд захиргааны байгууллага хүлээлгэн өгсөн баримттай танилцаж хариу өгнө. Хэрвээ шийдвэрлэлтийн явцад ямар нэг өөр өргөдөл өгч байвал (жнь: шийдвэрлэлтийг түр зогсоох өргөдөл), 2 хувь өргөдөл авч ир, алба хаагч 1 хувийг авч 2 – дах хувь дээр хүлээн авсан тамга дарж өгнө.

## ҮНЭНЧ МЭДЭГДЭЛ

Та хэрэгтэй баримтаа бүрдүүлж чадахгүй байна уу? Үнэнч мэдэгдлээр орлуулж болно.

- Үнэнч мэдэгдлээр тухайн байдлыг үнэн гэдгийг баталж байгаа, тийм учираас зөвхөн үнэн мэдээлэл хүргэнэ үү. Хэрвээ таны үнэнч мэдэгдлийг шалгаад үнэн бус байвал таны оршин суух өргөдлийг хэрэгсэхгүй болгоно.
- Үнэнч мэдэгдэлд таны байх ёстой мэдээллүүд: **хувийн мэдээлэл, үнэн гэсэн тухайн байдал, таны гарын үсэг, өдөр, газар.**

## ОРШИН СУУХ ОРЛОГЫН ДҮНГ НЯГТЛАХ

Зарим өргөдөлд сарын цэвэр орлогыг нотлохыг шаарддаг, орлого нь байнгых байх ёстой (жнь: бизнес эрхлэх, гэр бүл хамтран амьдрах). Оршин суух орлогонд байрны нормын зардал нөлөөлнө. Оршин суух орлогын хэмжээ хэдэн хүн нэг гэрт амьдарч байгаагаас шалтгаална.

## ӨРГӨДӨЛ ГАРГАСАН, ЦААШДАА ЯАХ ВЭ?

Өргөдлийн шийдвэрийг хуулинд заасан хугацаанд гаргах ёстой. Чухал хугацаануудын жагсаалт доорхи ДХЯ – ын цахим хуудсанд байгаа:

<http://www.mvcr.cz/clanek/obcane-tretich-zemi-prubeh-rizeni-lhuty-a-pocitani-casu.aspx>

Та өргөдлийн шийдвэрээ доорхи ДХЯ –ын цахим хуудаснаас байнга харж болно:


<http://www.mvcr.cz/clanek/informace-o-stavu-rizeni.aspx>

## ЗААСАН ХУГАЦААНД ШИЙДЭГДЭЭГҮЙ

Хуулинд заасан хугацаа дууссан ч шийдэгдээгүй байна уу? Шалтгаан байж магадгүй:

- **Өргөдөл болон хэрэгтэй хавсралтуудаа гаргаж өгсөнөө** шалга. Хэрвээ ямар нэг баримт дутаж байвал – захиргааны байгууллага өргөдлийг түр зогсоож дутуу материалаа нөхөж өгөхийг шаардана.
- Захиргааны байгууллага таны хүсэлтийн дагуу шийдвэрийг түр зогсоосон.
- Захиргааны байгууллага шийдвэрлэлтийг түр зогсоож – бусад чухал нөхцөлийн шийдвэр гарахыг хүлээнэ.


Хэрвээ шийдвэр шалтгаангүй хугацаандаа гараагүй бол та шийдвэрлэлтийг түргэсгэх өргөдөл ба гомдол гаргах эрхтэй.

 Дэлгэрэнгүй мэдээллийг гадаадуудын оршин суухыг хариуцсан хэлтэс дээр байдаг манай ажилчидад хандана уу, танд туслана.

## ГАДААД РУУ АЯЛАХ


Та гадаад руу аялах гэж байгаа, гэхдээ таны удаан хугацааны оршин суух зөвшөөрөл шийдэгдээгүй байгаа юу?


### 1. Түр хугацааны виз хүсээрэй

- Түр хугацааны виз таныг Чех улсад хууль журмын дагуу байгааг нотолно
  - Гааль ба Чех – с явахад та цагдаагын шалгалтанд түр хугацааны виз үзүүлж болно. Чехийн нутаг дэвсгэрээс гарж орж ба, шенгений орнуудаар аялаж болно.
-  Хэрвээ танд түр хугацааны визийг гадаад паспорт дээр дарж өгсөн, тэр хооронд шинэ паспорттой болсон бол түр хугацааны визтэй паспортоо биедээ авч явах ёстой.
- Гадаадуудын оршин суухыг хариуцсан хэлтсээс түр хугацааны виз хүсээрэй. Биечлэн очсоны дараа гадаад паспорт дээр чинь дарж өгнө.

## **Хэрвээ та урт хугацаагаар гадагшаа яваад таны оршин суух зөвшөөрлийн хугацаа буцаж ирэхээс чинь өмнө дуусч байна уу?**


- Түр хугацааны виз хүсээд ба яагаад хүсэж байгаа шалтгаанаа тайлбарлаад мөн захиргааны байгууллагад өөрийнхөө нэр дээр онгоцны билет захиалсан хуудсаа өг. Захиргааны байгууллага таны түр хугацааны визний хүсэлтийг зөвшөөрнө (татгалзаж болно).

 Хэрвээ та хувиараа бизнес эрхлэх зөвшөөрөлтэй бол, түр хугацааны виз ажил үйлчилгээ эрхлэх бүтгэлийн захиргаанд оршин суух зөвшөөрлөө батлана.

 Түр хугацааны оршин суух зөвшөөрөл өргөдөл гаргагч нар түр хугацааны виз авах эрхгүй. Чехийн нутаг дэвсгэрт зөвхөн өргөдөл шийдтэл байх эрхтэй. Чех улсаас гармаар байвал, гадаад паспорт дээр наадаг тусгай зөвшөөрөл хүсэх ёстой. Тэр нь тус улсаас ба шенгенээс гарах боломж олгоно. Чехийн нутаг дэвсгэрт буцаж орж ирэхийн тулд Чехийн ЭСЯ – с виз хүснэ.


## **2. Захиргааны байгууллагад гадаадруу зорчихоо мэдэгд**


- Гадаадруу зорчих мэдэгдлээ гадаадад байх хаягтайгаа хамт үнэнч мэдэгдэлдээ бичээд явуул. Өргөдлийн шийдвэрлэлтийг түр зогсоомооргүй байвал найдвартай хүнд захиа хүлээж авах итгэмжлэл үлдээнэ үү.

 Хэрвээ та өргөдлөө гаргахдаа хэсэг хугацаанд гадагшаа явхаа мэдэж байвал өргөдөл өгч байгаа маягт дээрээ явах хугацаа ба түр холбогдох хаягаа үлдээнэ үү.

## **Та удаан хугацаагаар явж байна уу (жнь: 30 – с дээш хоног)?**

- Өргөдлийн шийдвэрлэлтийг түр зогсоох хүсэлт гаргана уу. Шалтгаан дээр нь гадаадруу явах хугацаа ба гадаадад байх хаягаа мэдэгднэ үү.
- Захиргааны байгууллага таны өргөдлийг зөвшөөрнө, тэгэхдээ зөвхөн шийдвэрлэлтийн зорилгод аюулгүй тохиолдолд ба шалтгаангүй шийдвэрлэлтийг зогсоох эсвэл хуулийн дагуу заасан үүргээ хангаагүй.

 Та уридчилаад тус улсад байхгүй байгаагаа мэдэгдвэл дутсан материалыг нөхөн бүрдүүлэх хугацаанаас хоцрохгүй.

 Биометрийн картаа (оршин суух зөвшөөрлийн үнэмлэх) биометрийн өгөгдөл авхуулсан өдөрөөс эхлэн 60 хоногийн дотор очиж авах үүрэгтэй, тэгэхгүй бол оршин суух зөвшөөрлийг цуцлана. Энэ үед ажиллагаагаа зогсоож болохгүй.


## МИНИЙ ӨРГӨДӨЛ НААШТАЙ ШИЙДВЭРЛЭГДСЭН , ОДОО ЯАХ ВЭ?


ДХЯ – н харьяа салбарт биометрийн өгөгдөл өгөх өдөрөө мэдэгднэ үү.

### БИОМЕТРИЙН КАРТ

Биометрийн карт бол оршин суух эрхийн үнэмлэх – биеийн байцаалт ба оршин суух зөвшөөрлөө нотолно уу. Өөрийн биедээ байнга авч яв, байхгүй тохиолдолд торгуулах магадлалтай.


- Хэл нэвтрэхэд танд биометрийн карт ба гадаад паспорт байх ёстой.
- Таны картны хугацаа хавсарсан баримтаас шатгаална (оршин суух зорилгоо биелүүлж байгаа баримт), эрүүл мэндийн даатгалын үнэмлэх ба байр олгосон баримт.

 Хэрвээ та урт хугацааны визтэй болвол, захиргааны байгууллагад биометрийн өгөгдөл өгөхөөс өмнө мэдэгдэл мэдэгдэх хэрэгтэй. Дараа нь мэдэгдсэн материалыг хүлээж авахгүй.

 Биометрийн картын хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд захиргааны байгууллагад буцааж өгнө.


Биометрийн карт хүлээн авах өдөрөө, та захиргааны хураамжаа бэлдсэн байгаарай:

- 2500 крон - тогтмол хураамж; (1000 крон - 15 нас хүртэл хүүхдүүд оршин суух зөвшөөрлийн хураамж)
- 4000 крон – хаях, гэмтээх, эсвэл хулгайд алдах тохиолдол; (2500 крон - 15 нас хүртэл хүүхдүүд)

 Биометрийн картаа хүлээн авахдаа шалгаж авна уу. Хүлээн авсан гарын үсгээр биометрийн карт асуудалгүй байгааг нотолно.

## ОРШИН СУУХ ЗОРИЛГО БА ОРШИН СУУХ ЗОРИЛОГЫГ СОЛИХ

Ямар нэг удаан оршин суух зөвшөөрөл, оршин суух зорилготой. Оршин сууж байх хугацаанд та олон төрлийн зорилгоор байж болно, жнь: суралцах, ажиллах, бизнес эрхлэх г. м. Та оршин суух зорилгоо өдөр болгон биелүүлэх ёстой.


 Хэрвээ та оршин суух зорилгоо биелүүлэхгүй байвал, захиргааны байгууллага таны оршин суух эрхийг зогсоож ба сунгах хүсэлтийг хэрэгсэхгүй.

Удаан хугацааны оршин суух зөвшөөрөл байгаа үед та оршин суух зорилгоо ногоон маягт бөглөж зорилго солих өргөдөл өгч болно. Доорхи зарим нэг хязгаарууд:


- Та удаан хугацааны оршин суух визтэй бол оршин суух зорилгоо сольж болохгүй
- Бизнес эрхлэх зорилгооруу тус улсад 2 жил оршин суусаны дараа өргөдөл өгч болно
- Дараагийн хязгаарнууд гэр бүлийн гишүүд, ногоон картны эзэмшигч нар, тус улсад хамгаалалттай гэх мэт хүмүүст хамаарна

## БИЗНЕС ЭРХЛЭГЧИД

Хэрвээ та Чех улсад хувиараа бизнес эрхэлж байгаа бол та удаан оршин суух зөвшөөрөл буюу түүний сунгалт хүсхээс өмнө хувиараа худалдаа наймаа эрхлэх зөвшөөрлөө сунгах хэрэгтэй.

 Захиргааны байгууллага таны өргөдлийн шийдвэрийг хугацаандаа гаргахгүй байвал, хувиараа худалдаа наймаа эрхлэх зөвшөөрлийн хүчинтэй хугацааг хянаж ба хугацаа нь дуусаж байгаа тохиолдолд түр хугацааны визээр сунгуулна.


## Татварын хураамжид анхаар

 Захиргааны байгууллага таны орлогоос нийгмийн даатгалын хураамж ба бусад зардлыг хасаж цэвэр орлогыг харгалзаж үзнэ. Тийм учираас татварын тайландаа бизнес эрхлэх 60% - н хураамжаа тооцож үзнэ үү.



## ГЭР БҮЛИЙН ГИШҮҮД

Гэр бүлийн хамтран амьдрах зорилгыг эхнэр, нөхөр, эцэг, эх ба хүүхдүүд ба ганц бие 65 – с дээш настай иргэд тус улсад эцэг эх эсвэл хүүхдүүд нь байгаа тохиолдолд хүсэж болно.

 Оршин суух зөвшөөрлийн хугацаа нь тус улсад байгаа гэр бүлийн гишүүний оршин суух зөвшөөрлийн хугацаанаас хамаарна.

### Тус улсад танд хүүхэд төрсөн үү?


Төрсөнөөс нь хойш 60 хоногийн дотор оршин суух зөвшөөрлийн өргөдлийг гаргана уу. Төрсний гэрчилгээ ба гадаад паспорт өргөдөлдөө хавсаргаж өгнө үү. Та хүүхэддээ өөрийн оршин суух эрхтэй адил өргөдөл гаргана уу – удаан хугацааны эсвэл байнгын.

## ОЮУТНУУД

**Суралцах** оршин суух зорилгыг зөвхөн зарим шалтгаанд хамаарагдана, жнь:

- **Магадлан итгэмжлэгдсэн** дунд сургууль, мэргэжлийн дээд сургууль ба дээд сургуульд суралцах
- Магадлан итгэмжлэн суралцахын хэлний бэлтгэл
- Магадлан итгэмжлэгдсэн боловсролын байгууллага (жнь: их сургууль) үнэггүй зохион байгуулж буй мэргэжлийн дадлага
- Тэтгэлэгтэй суралцах г. м

Бусад **боловсролын** тохиолдолд „**бусад**“ оршин суух зорилгод хамаарна.

 Ямар нэгэн боловсролын дамжаа доод тал нь 7 хоногийн 20 цаг байх ёстой.

**Хэрвээ би тус улсад суралцаж байхдаа оюутны солилцоо ЕРАСМУС эсвэл өөр гадаадруу явах оюутны солилцоонд хамаарагдвал яах вэ?**

Хэрвээ та гадаадруу оюутан солилцоогоор явбал (жнь: ЕРАСМУС), тус улсад суралцах оршин суух зорилгыг доорхи нөхцлүүдийг хангасан тохиолдолд биелүүлж байх болно.

- Оюутны солилцоонд байх үедээ Чех их сургуулийн оюутан хэвээрээ байна

- Гадаадад оюутны солилцоонд байх үедээ Чех их сургуулийн оюутны шаардлагыг хангаж байгаа
- Оюутны солилцоо Чех их сургуулиар зохион байгуулагдсан эсвэл зуучлагдсан

Оршин суух байрлалаа сольсон тохиолдолд та захиргааны байгууллагад 30 хоногийн дотор мэдэгдэх ёстой. Гадаадад оршин суух байрны баримт өгөх шаардлагагүй. Захиргааны байгууллагад гадаадад байх түр холбогдох хаягаа мэдэгднэ үү.

## **Сургалтаа төгссөн тохиолдолд Чех улсад үлдмээр байвал яах вэ?**

Төгсгөлийн улсын шалгалтын өдөр бол таны сургалтын сүүлийн өдөр. Оршин суух сургалтын зорилго нь биелүүлэгдсэн. Хэрвээ сургалтаа төгсөөд тус улсад үлдмээр байвал, оршин суух зорилгоо солих өргөдөлөө (ажил, бизнес эрхлэх, бусад. . . ) суралцаж байгаа сүүлийн өдөр гаргах хэрэгтэй. Сургуулиа төгссөний дараах өдөрөөс шинэ оршин суух зорилгоо биелүүлэх хэрэгтэй, тэгэхгүй бол захиргааны байгууллага таны өргөдлийг зогсоох болно.

Хэрвээ та бакалаврын сургалтаа төгсөөд магистрийн сургалтанд үргэлжлүүлэн сурж байгаа бол захиргааны байгууллага суралцах оршин суух зорилгыг биелүүлж байгаа гэж тооцно. Энэ үед сургалтын оршин суух зорилгоо биелүүлж байгаагаа шалгалтанд орох баримт эсвэл үргэлжлүүлж магистрийн сургалтанд бүртгүүлсэн баримтыг үзүүлнэ үү. Суралцах зэргийн хооронд алгассан хугацаа байж болохгүй.

## **АЖИЛЧИД**

Хэрвээ та Чех улсад ажилламаар байвал танд оршин суух эрх бас **ажилын зөвшөөрөл** хэрэгтэй.


Таны оршин суух эрхийг ажлын зөвшөөрөлтэй адил хугацаагаар сунгаж өгнө. Ажлын зөвшөөрлийн хугацаа таны мэргэжилд шаардлагатай боловсролоос шалтгаална.


Доорхи нөхцлүүдэд ажлын зөвшөөрөл **шаардахгүй**

- Чех улсад байнгын оршин суух зөвшөөрөлтэй
- Чех улсад цагаачилсан эсвэл нэмэлт хамгаалалттай
- Байнгын оршин суух эсвэл цагаачлалын зөвшөөрөлтэй удаан хугацааны гэр бүл хамтран амьдрах зорилготой

■ Тус улсад дунд / дээд / их сургууль төгссөн

■ Дунд дээд их сургуульд суралцаж байгаа ба ирээдүйн мэргэжилдээ бэлдэж байгаа

 Ажилын зөвшөөрөл хүсэх ба сунгах өргөдөлийн маягт доорхи хаяг дээр байгаа: [http://portal.mpsv.cz/sz/zahr\\_zam/zz\\_zamest\\_cizincu](http://portal.mpsv.cz/sz/zahr_zam/zz_zamest_cizincu)


 Ажил эрхэлж байгаа гадаадын иргэд нийтийн эрүүл мэндийн даатгалын бүртгэлд хамаарагдана. Нийтийн эрүүл мэндийн даатгалын гадаад иргэдийн сарын хураамжыг нийт орлогоос нь дүнгийн гаргана (жнь: ажлаас гадна хувиараа бизнес эрхлэх).

*Жнь: Бакалаерын зэргийн оюутан 7 хоногт 20 цаг гэрээгээр ажиллах боллоо. Ажлын зөвшөөрөл хэрэггүй, нийтийн эрүүл мэндийн даатгалд хамаарч байгаа тийм учираас удаан хугацааны оршин суух зөвшөөрлөө сунгахдаа бүрэн эрүүл мэндийн даатгалын оронд нийтийн эрүүл мэндийн даатгалыг өгч болно.*

Ажлын зорилгоор оршин суух бусад төрлүүд – ногоон ба цэнхэр картнууд. Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи хаягаар авна уу:

[http://portal.mpsv.cz/sz/zahr\\_zam/zelka](http://portal.mpsv.cz/sz/zahr_zam/zelka)

2013 он дуустал шинэ хуулийн өөрчлөлтийг батлаж ажлын зөвшөөрөл ба ажлын оршин суух зөвшөөрлийг нэгтгэж „**ажлын карт**“ олгоно. Ажлын карт удаан хугацааны ажиллах зорилгоор оршин суух зөвшөөрлийг, ажлын зөвшөөрөл ба ногоон картыг орлоно.


 Дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл манай байгууллагатай холбогдно уу.

## БАЙНГЫН ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ГЭЖ ЮУ ВЭ БА ЯАЖ ОЛГОГДОХ ВЭ?

Байнгын оршин суух зөвшөөрөл нь давуу талууд олгоно:

- Шууд тус улсын регистрийн дугаар олгогдно;
- Нийтийн эрүүл мэндийн даатгалд хамаарагдана;
- Чех улсын иргэдтэй адил ажиллах, бизнес эрхлэх, боловсрох ба үл хөдлөх хөрөнгө худалдан авах эрхтэй болдог;
- Харъяа хөдөлмөрийн албад ажил хүссэн өргөдөл гаргах ба олон төрлийн тэтгэмж хүсэх.

Байнгын оршин суух зөвшөөрөл тус улсад **5 жил тасралтгүй удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй** байсны дараа олгогдно.

 Хэрвээ та суралцах зорилгоор байгаа бол оршин суугаа хугацаа нь хагасаар тооцогдно.


5 жилийн дотор аялж болно. 5 жил тасралтгүй байх үедээ Чех улсын нутаг дэвсгэрээс гадна нийт 10 сараас илүү байж болохгүй. Нэг дор аялахдаа 6 сараас хэтэрч болохгүй.

Мөн Чех хэлийг А1 түвшинд мэдэж байх ёстой. Чех хэлний шалгалт үнэгүй өгөх хуудсаа гадаадуудын оршин суух хэлтсүүдээс авч болно. Чех хэлний дамжаанд хаана суух эсвэл хаана Чех хэлний шалгалтаа өгөх дэлгэрэнгүй мэдээллийг энэ хаягнаас авна уу: <http://cestina-pro-cizince.cz>

Өргөдөлтэйгөө хавсран

- Гадаад паспорт
- 2 хувь зураг
- Байр хөлсөлсний гэрээ эсвэл байр хангагдсан тодорхойлолт
- Орлогын тодорхойлолт (цэвэр цалингын тодорхойлолт, татварын тайлангын тодорхойлолт ба өргүй гэсэн тодорхойлолт, г. м)
- Хэл эзэмшсэн гэрчилгээ

Хэрвээ та байнгын оршин суух зөвшөөрлийг тус улсад 5 жил тасралтгүй байсны дараа хүсэж байгаа бол удаан хугацаанд ЕС/**ЕУ-н байнгын оршин суугчын** нөхцлийг хангана.

 ЕХ-ы бусад улсад ажилах, бизнес эрхлэх ба оршин суух эрх танд олгогдоно.

Дэлгэрэнгүй мэдээлэл: [http://europa.eu/legislation\\_summaries/justice\\_freedom\\_security/free\\_movement\\_of\\_persons\\_asylum\\_immigration/123034\\_cs.htm](http://europa.eu/legislation_summaries/justice_freedom_security/free_movement_of_persons_asylum_immigration/123034_cs.htm)

## ХҮЛЭЭЛГИЙН ВИЗТЭЙ ОРШИН СУУНА ГЭЖ ЮУ ВЭ?

Чех улсаас ямар нэг шалтгаантай гарч чадахгүй тохиолдолд олгогддог. Жнь доорхи шалтгаануудаас:

- Байнгын оршин суух зөвшөөрлийг захиргааны байгууллага 2 сараас хэтэрсэн хугацаанд шийдээгүй


- Тус улсын нутаг дэвсгэрээс танд явж чадахгүй онцгой шалтгаан (жнь: хүнд өвчин)


Хүлээлгийн визний өргөдлийг захиргааны байгууллагад гаргана. Хэрвээ гарч чадахгүй шалтгаан үргэлжилсээр байвал сунгаж болно. Гарч чадахгүй гэх шалтгаангүй болвол захиргааны байгууллага хүлээлгийн визийг хүчингүй болгоно.

*Жнь: Эцэг эх хүүхдээ тус улсад жуулчны визээр авч ирж хүүхэддээ байнгын оршин суух зөвшөөрлийг хүссэн. Өргөдлийг шийдээгүй байгаа ба жуулчны визийн хугацаа дууссан. Хүүхэд нь тус улсад байнгын оршин суух зөвшөөрлийн шийдвэрийг зөвхөн хүлээлгийн виз хүсээд олгогдсон тохиолдолд байж болно.*

## ГАРАХ ЗАХИРАМЖ ГЭЖ ЮУ ВЭ?


Хэрвээ та Чех улсад оршин суух зөвшөөрөл байхгүй бол ба та Чех улсаас гарах ёстой бол таны паспортод гарах захирамж дарж өгнө. Гарах захирамж танд явахаас өмнө асуудлуудаа шийдэж ба Чех улсаас гархад зориулсан. 60 хоног хүртэл олгогдно. Та гарах захирамжаа богино хугацаагаар даруулсан бол сунгалт хүсэж болно.

 Хугацаа дууссаны дараа тус улсаас гарахгүй бол, таныг захиргааны журмаар албадан гаргах ба буцаж орохыг хориглох аюултай.

 Хэрвээ та шенгений нутаг дэвсгэрээр гармаар байвал цагдаа дээр богино хугацааны дамжин гарах виз хүснэ. Хүсэлтийг 10 хоног дотор шийднэ.


## ТАНЫ ҮҮРЭГ


- Чех улсад ирсэний дараа 3 хоногийн дотор цагдаад мэдэгдэх эрхтэй. Хэрвээ таны өмнөөс байр түрээслүүлэгч мэдэгдээгүй бол ( жнь: зочид буудал)
- Байнга өөрийн биед виз буюу биометрийн карт ба эрүүл мэндийн даатгалын үнэмлэх төлсөн баримтаа хамт авч яв.


- Биометрийн картын эсвэл оршин суух зөвшөөрлийн үнэмлэхний хугацаа нь дууссан бол картаа авсан гадаадуудыг хариуцах хэлтэст буцааж өг.
  - Хэрвээ та оршин суух үнэмлэхээ алга болгосон, гэмтээсэн, устгасан буюу хулгайд алдсан тохиолдолд 3 хоногийн дотор мэдэгдэх ёстой.
  - Оршин суух зөвшөөрлийн үнэмлэх дээр харагдаж байгаа мэдээлэл (жнь: овог гадаад паспорт г. м) 3 хоногийн дотор захиргааны байгууллагад мэдэгднэ үү.
  - Оршин сууж байгаа хаягаа сольсон тохиолдолд захиргааны байгууллагад 30 хоногийн дотор мэдэгднэ (байнгын оршин суух зөвшөөрөлтэй бол хаягаа солиод 6 сараас дээш амьдарвал).
-  Хэрвээ хаягаа солиод хугацаандаа мэдэгдэхгүй бол оршин суух зөвшөөрлийн тухай чухал мэдээллүүдийг мэдэхгүй байх болно.
- Зөвхөн үнэн зөв мэдээлэл мэдэгднэ үү


## ЗӨВЛӨМЖ

- **Битгий хүлээ урьдчилаад захиалга өг!** Хэрвээ та гадаадыг хариуцсан хэсэг дээр биечлэн очих хэрэгтэй бол оочирлож хүүлээхгүйн тулд урьдчилаад захиалж болно. Захиалах хуудас нь: <http://www.mvcr.cz/clanek/sluzby-pro-verejnost-informace-pro-cizince-kontakty.aspx>
- **Зөвхөн бичсэн мэдээлэлд анхаар!** Алба хаагчын амаар өгсөн мэдээлэл хүчингүй. Албан ёсны мэдээлэл авахыг хүсвэл бичгээр авах хүсэлт гарга.
- **Бичиг баримтын асуудлаа өөрөө хариуцаж бай.** Хэрвээ хүнээр төлөөлүүлэх хэрэгтэй бол өөрийн итгэдэг найдвартай хүнрүү ханд эсвэл та өмгөөлөгчрүү хандаж болно, тэр танд хуулийн зөвлөгөө өгч таныг төлөөлж ба бусад асуудлыг хөлсний төлбөрийн дагуу шийдэж өгнө. Үйл ажиллагаа явуулж байгаа өмгөөлөгч болгон Чехийн өмгөөлөгчийн танхимын гишүүн гэсэн дугаартай байх ёстой.

 Хэрвээ танд ямар нэг өөр хүн хуулийн зөвлөгөө өгч байвал, танаас мөнгөний урамшуулал нэхэх ёсгүй.

 Ямарч төлөөлөгч нааштай шийдвэрийг байнгын мөнгө төлсөн ч баталж чадахгүй.

 Хэнээр итгэмжлэл өгч төлөөлж байгаагаа сайн анхаар.

 Ихэнх оршин суухтай холбоотой асуудлуудыг та өөрөө хөөцөлдөж шийдэж чадна. Төрийн бус байгууллагууд гадаадуудад үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө өгдөг.

## ДХЯ-Н САЛБАРТ ХЭЛМЭРЧ ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРГЭНЭ

ЧУ-н ДХЯ-н гадаад иргэдийг хариуцсан салбар дээр ИнБазе салбарууд:

- ДХЯ-н салбар Kopčova 188/32, Praha 3 – Žižkov (2-р давхарт 3 дагч орны иргэдийн хэсэгт)
- ДХЯ-н салбар Cigbňkova 1861/2, Praha 4 – Chodov (1-р давхарт 3 дагч орны иргэдийн хэсэгт)
- ДХЯ-н салбар Nad Vršovskou horou 88/4, Praha 10 – Bohdalec (2-р давхарт 3 дагч орны иргэдийн хэсэгт)

### Бидний туслалцаа зөвлөгөө дараах төрлүүдээр:

- Оршин суух зөвшөөрлийн талаар анхан шатны зөвлөгөө
- Танд маягт бөглөхөд туслана
- Хавсаргаж өгч байгаа бичиг баримтыг шалгаж өгнө
- Монгол, араб, вьетнам, орос, франц болон англи хэлрүү орчуулга хийнэ
- Урьдчилаад захиалвал бид тантай албан байгууллагатай харилцах үед хамт явж хэлмэрчлэх үйлчилгээг хүргэнэ
- Нийгмийн асуудлаар үйлчилгээ үзүүлнэ

Тухайн цагт байгаа ажилын цагын хуваарь манай цахим хуудсанд байгаа [www.inbaze.cz](http://www.inbaze.cz)

InBáze, o. s.

Legerova 50  
120 00 Praha 2

info@inbaze.cz  
http://inbaze.cz



224 941 415  
739 037 353



socialni@inbaze.cz  
pravni@inbaze.cz



608 528 806  
608 817 531  
viet@inbaze.cz



775 283 481  
mon@inbaze.cz



732 547 886  
rus@inbaze.cz



732 549 586  
arab@inbaze.cz



773 898 680  
fr@inbaze.cz

## **Төрийн бус буюу ашгийн бус байгууллагууд гадаад иргэдэд үнэ төлбөргүй зөвөлгөө өгч байна**

**ПРАГ ХОТ +  
ТӨВ ЧЕХ**

### **Poradna pro integraci**

Opletalova 6, 110 00 Praha 1  
tel. : 224 216 758  
e-mail: [paha@p-p-i.cz](mailto:paha@p-p-i.cz)  
web: <http://p-p-i.cz>

### **Sdružení pro integraci a migraci**

Baranova 33, 130 00 Praha 3  
tel. : 224 224 379, 603 547 450  
e-mail: [poradna@refug.cz](mailto:poradna@refug.cz)  
web: <http://www.migrace.com>

### **Organizace pro pomoc uprchlíkům**

Kovářská 939/4, 190 00 Praha 9  
tel. : 284 683 714, 284 683 545  
e-mail: [opu@opu.cz](mailto:opu@opu.cz)  
web: <http://www.opu.cz>

### **Integrační centrum Praha**

Žitná 1574/51, 110 00 Praha 1  
tel. : 252 543 846  
e-mail: [info@icpraha.com](mailto:info@icpraha.com)  
web: <http://icpraha.com>

### **META – Sdružení pro příležitosti mladých migrantů**

Ječná 17, 120 00 Praha 2  
tel. : 222 521 446, 775 339 003  
e-mail: [info@meta-os.cz](mailto:info@meta-os.cz)  
web: <http://meta-os.cz>

### **Poradna pro občanství, občanská a lidská práva**

Ječná 7, 120 00 Praha 2  
tel. : 270 003 280, 270 003 281  
e-mail: [poradna@poradna-prava.cz](mailto:poradna@poradna-prava.cz)  
web: <http://www.poradna-prava.cz>

### **Mezinárodní organizace pro migraci**

Argentinská 38, 170 00 Praha 7  
tel. : 233 370 160  
e-mail: [prague@iom.int](mailto:prague@iom.int)  
web: <http://www.iom.cz>

### **Klub Hanoi**

Libušská 319, 142 00 Praha 4  
tel. : 603 583 690, 608 535 792  
e-mail: [klubhanoi@klubhanoi.cz](mailto:klubhanoi@klubhanoi.cz)  
web: <http://klubhanoi.cz>

### **Centrum pro integraci cizinců**

Kubelíkova 55, 130 00 Praha 3  
tel. : 222 360 452, 222 360 834  
e-mail: [info@cicpraha.org](mailto:info@cicpraha.org)  
web: <http://www.cicpraha.org>

### **La Strada Česká republika**

P. O. Box 305, 111 21 Praha 1  
tel. : 222 71 71 71, 800 07 77 77  
e-mail: [pomoc@strada.cz](mailto:pomoc@strada.cz)  
web: <http://www.strada.cz>

### **Poradna pro migranty a uprchlíky (Arcidiézní charita Praha)**

Pernerova 20, 186 00 Praha 8  
tel. : 224 813 418, 605 268 444  
e-mail: [migrace@praha.charita.cz](mailto:migrace@praha.charita.cz)  
web: <http://praha.charita.cz>

### **Diakonie Českobratrské církve evan- gelické**

Belgická 22, 120 00 Praha 2  
tel. : 242 487 811-2  
e-mail: [info@diakonie.cz](mailto:info@diakonie.cz)  
web: <http://www.diakonie.cz/>